

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Багануур ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/13/НА-СТА-ТӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:51-261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Д.Энхдалай Утас:51-260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn Аудитор: М.Ганбаатар Утас: 51-261628 Цахим хаяг: ganbaatar.m@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ихмонгол хөлөг аудит ХХК-ийн захирал: С.Тунгалаг Утас: 70001778 Цахим хаяг: info@imkaudit.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	1
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 Компанийн үйл ажиллагаа	11
3.2 Компанийн гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	12
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	13
3.5.1 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин	13
3.5.2 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	13
3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1 Төлбөрийн акт	19
5.2 Албан шаардлага	19
5.3 Зөвлөмж	20
5.4 Багануур сувилал ХХК-ийн санхүүгийн тайланд хийсэн аудит	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГЕН	Гэрээний ерөнхий нөхцөл
ДЦС	Дулааны цахилгаан станц
ДЭХГ	Дулааны эрчим хүчний газар
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
МЯН.ТН	Мянган тонн
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТӨҮГ	Төрийн өмчид үйлдвэрийн газар
ТЭЗҮҮЗТ	Техник эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшин
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

БАГАНУУР ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ
Т.ОТГОНБОЛД ТАНАА

2026.03.16 № 06/723
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Багануур ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Багануур ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 16,841.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Худалдан авах ажиллагааг зохин байгуулахдаа нээлттэй тендер шалгаруулалт, харьцуулалтын арга ашиглаагүй нийт 16 байгууллагаас 1,365.7 сая төгрөгийн барааг шууд худалдан авсан;
- Хөрс тээврийн автосамосвал нийлүүлэх 11,600.0 сая төгрөгийн 25/12-54 дүгээр гэрээний тусгай нөхцөлийн дагуу барааг хугацаанд нийлүүлээгүй, үүргийн хэрэгжилтийг хангуулж ажиллаагүй;
- Санхүүгийн тайланд тайлагнасан хойшлогдсон татварын хөрөнгө дансны 764.4 сая төгрөгийн үлдэгдэлд 2020 оноос хойш тооцоолол хийгээгүй, 1,255.4 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;
- Үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 1797 нэр төрлийн 83,284.2 сая төгрөгийн хөрөнгийг бодит үнэ, цэнээр бүртгээгүй.

Эдгээр зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.12, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3.6, 40 дүгээр зүйлийн 40.4-д заасантай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Багануур ХК нь 2025 онд 4.8 сая.тн нүүрс олборлож, борлуулахын тулд 22.3 сая.м3 хөрс хуулж, нийт 32.2 сая.м3 уулын ажил хийхээр төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 4.8 сая.тн нүүрс олборлож, 22.9 сая.м3 хөрс хуулж, 33.6 сая.м3 уулын ажил гүйцэтгэсэн байна.

Нүүрс-пиролизын үйлдвэрийн төслийн ТЭЗҮ боловсруулах олон улсын нээлттэй тендерийг 2025 оны 3 дугаар сарын 08-ны өдөр зарлаж, Тендерийн үнэлгээгээр Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Седин инженеринг компани шалгарч, төслийн ТЭЗҮ-г боловсруулсан байна.

Төслийн ТЭЗҮ, зураг төслийг Аж үйлдвэр эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр батлуулахаар шинжээч нар томилогдон ажиллаж байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 157 дугаар тогтоолын дагуу Сангийн яам, Эрдэнэс Монгол ХХК, Багануур ХК-тай гуравласан гэрээ байгуулж, Эрдэнэс Монгол ХХК нь 29,982.1 сая төгрөгийн Засгийн газрын гадаад зээллэгийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээний дагуу үүссэн хугацаа хэтэрсэн өр төлбөр болон дамжуулан зээлийг барагдуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант хугацаанд Монголын хөрөнгийн биржээр 119 өдөр Багануур ХК-ийн 17,288 ширхэг хувьцаа нийт 34.0 сая төгрөгөөр арилжигдсан байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 3 дугаар тогтоолоор 2024 оны цэвэр ашгийн 30 хувь буюу 495.4 сая төгрөгийг ногдол ашигт хуваарилж, нэгж хувьцаанд 23.62 (хорин гурван төгрөг жаран хоёр мөнгө) төгрөг байхаар тогтоосон байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	2024 оны 12 сарын 31-ний өдөр	2025 оны 12 сарын 31-ний өдөр
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	6,366,982,530.30	7,909,849,201.67
1.1.2	Дансны авлага	4,690,594,574.18	6,932,466,641.03
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	2,640,878.45	153,225,618.46
1.1.4	Бусад авлага	1,951,272,638.91	1,589,896,053.79
1.1.6	Бараа материал	49,105,511,778.26	50,066,362,235.16
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	2,311,999,968.54	2,570,356,806.63
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	64,429,002,368.64	69,222,156,556.74
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	168,599,587,652.46	172,378,887,067.49
1.2.2	Биет бус хөрөнгө	4,616,514,877.36	4,409,529,558.10
1.2.3	Уул уурхайн хөрөнгө / УУХөгжүүлэлт, Хөрс хуулалт/	25,169,955,715.80	27,646,923,325.70
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	615,704,292.34	615,704,292.34
1.2.5	Биологийн хөрөнгө мод суулгац	-	577,125,545.00
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	764,393,387.00	764,393,387.00
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	1,328,603,776.54	520,020,644.32
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	201,094,759,701.50	206,912,583,819.95
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	265,523,762,070.14	276,134,740,376.69
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	62,906,234,850.58	71,095,189,392.79
2.1.1.2	Цалингийн өглөг	2,589,819,924.00	2,764,096,203.44
2.1.1.3	Татварын өр	76,622,743,332.17	17,042,145,897.09
2.1.1.5	Богино хугацаат зээл	13,356,223,186.00	137,773,982,106.47
2.1.1.6	Хүүгийн өглөг	-	8,585,057,907.16
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	1,550,967,618.04	3,064,264,939.04
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	97,299,473.76	74,777,504.65
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	157,123,288,384.55	240,399,513,950.64
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	91,243,334,940.28	19,373,897,380.01
2.1.2.2	Нөөц / өр төлбөр/	1,167,266,443.09	1,167,266,443.09
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	9,136,501,019.22	9,365,357,056.95
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	101,547,102,402.59	29,906,520,880.05
2.2	Өр төлбөрийн нийт дүн	258,670,390,787.14	270,306,034,830.69
2.3	Эздийн өмч	2,097,436,000.00	2,097,436,000.00
2.3.1	Төрийн өмч	1,573,077,000.00	1,573,077,000.00
2.3.2	Хувийн өмч	524,359,000.00	524,359,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	63,295,572,091.86	63,295,572,091.86
2.3.8	Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг	3,702,426,000.00	3,702,426,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(62,242,062,808.86)	(63,266,728,545.86)
2.3.11	Эздийн өмчийн дүн	6,853,371,283.00	5,828,705,546.00
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	265,523,762,070.14	276,134,740,376.69

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12 сарын 31-ний өдөр	2025 оны 12 сарын 31-ний өдөр
1	Борлуулалтын орлого (цэвэр)	237,581,225,691.92	267,054,959,058.06
2	Борлуулалтын өртөг	217,369,427,229.47	239,280,241,332.54
3	Нийт ашиг (алдагдал)	20,211,798,462.45	27,774,717,725.52
4	Түрээсийн орлого	45,081,745.46	119,326,218.16
5	Хүүгийн орлого	23,265,228.67	69,346,173.78
6	Ногдол ашгийн орлого	377,061,963.56	104,981,458.07
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	2,744,391,353.17	889,630,640.31
9	Борлуулалт, маркетингийн зардал	694,205,527.44	1,104,521,263.80
10	Ерөнхий ба удирдлагын зардал	15,975,522,292.00	18,124,508,179.75
11	Санхүүгийн зардал	4,008,421,198.11	4,348,756,718.60
12	Бусад зардал	1,335,828,392.78	2,620,889,604.84
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	819,020,429.18	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	2,206,641,772.16	2,759,326,448.85
19	Орлогын татварын зардал	554,984,490.04	856,073,875.57
20	Татварын дараах ашиг (алдагдал)	1,651,657,282.12	1,903,252,573.28
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	1,651,657,282.12	1,903,252,573.28
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	1,651,657,282.12	1,903,252,573.28
25	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	2,097,436,000.00	63,295,572,091.86	3,702,426,000.00	(40,219,530,431.97)	28,875,903,659.89
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	2,097,436,000.00	63,295,572,091.86	3,702,426,000.00	(40,219,530,431.97)	28,875,903,659.89
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	-	(23,674,189,659.01)	(23,674,189,659.01)
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	1,651,657,282.12	1,651,657,282.12
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	2,097,436,000.00	63,295,572,091.86	3,702,426,000.00	(62,242,062,808.86)	6,853,371,283.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	2,097,436,000.00	63,295,572,091.86	3,702,426,000.00	(62,242,062,808.86)	6,853,371,283.00
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	-	(3,422,118,215.14)	(3,422,118,215.14)
Зарласан ногдол ашиг	-	-	-	494,199,906.86	494,199,906.86
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	1,903,252,573.28	1,903,252,573.28
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
2025 оны 12 сарын 31-ний өдөр	2,097,436,000.00	63,295,572,091.86	3,702,426,000.00	(63,266,728,545.86)	5,828,705,546.00

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12 сарын 31-ний өдөр	2025 оны 12 сарын 31-ний өдөр
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	236,751,140,252.90	277,500,976,650.49
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	236,221,865,182.01	277,069,445,701.49
1.1.4	Буцаан авсан албан татвар	384,739,247.55	393,447,949.76
1.1.6	Бусад мөнгөн орлого	144,535,823.34	38,082,999.24
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	215,058,086,616.04	305,896,876,999.48
1.2.1	Ажиллагчдад төлсөн	48,219,477,862.73	55,657,189,616.30
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	23,876,227,349.56	19,212,086,011.91
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	77,030,502,580.61	89,783,580,454.36
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	104,500.00	-
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	49,102,924,244.98	43,166,757,205.43
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	429,205,919.32	162,821,922.22
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	10,059,756,471.33	85,102,592,307.67
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		
1.2.9	Бусад мөнгөн зарлага	6,339,887,687.51	12,811,849,481.59
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	21,693,053,636.86	(28,395,900,348.99)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	23,257,056.10	69,346,173.78
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	23,257,056.10	69,346,173.78
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	20,602,209,836.06	25,716,090,936.36
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	20,337,117,651.70	25,716,090,936.36
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	265,092,184.36	
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(20,578,952,779.96)	(25,646,744,762.58)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	40,071,275,287.00	110,950,950,810.83
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	40,071,275,287.00	110,950,950,810.83
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	37,235,628,356.79	55,365,439,027.89
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	37,235,569,846.79	55,365,439,027.89
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	58,510.00	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,835,646,930.21	55,585,511,782.94
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	3,949,747,787.11	1,542,866,671.37
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,417,234,743.19	6,366,982,530.30
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,366,982,530.30	7,909,849,201.67

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Х/н	2024 он	2025 он		Харьцуулалт			
			Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/ 2025 гүйц	Хувь	2025 төл/ 2025 гүйцэт	Хувь
Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:			242,434,527.0	263,940,986.9	268,238,243.6	25,803,716.6	110.6	4,297,256.7	101.6
1	Нүүрс борлуулалт	м.төг	237,581,225.7	262,734,728.8	267,054,959.1	29,473,733.4	112.4	4,320,230.3	101.6
	Бусад орлого	м.төг	4,853,301.3	1,206,258.1	1,183,284.5	(3,670,016.8)	24.4	(22,973.6)	98.1
2	Нийт орлого	м.төг	242,434,527.0	263,940,986.9	268,238,243.6	25,803,716.6	110.6	4,297,256.7	101.6
3	Нийт зардал	м.төг	240,227,885.2	263,833,457.8	265,485,829.5	25,257,944.3	110.5	1,652,371.7	100.6
	Үүнээс: Удирдлагын зардал	м.төг	15,975,522.3	22,675,961.9	18,693,313.1	2,717,790.8	117.0	(3,982,648.8)	82.4
4	Татварын өмнөх ашиг	м.төг	2,206,641.7	107,529.1	2,752,414.0	545,772.3	124.7	2,644,884.9	2,559.7
5	Цэвэр ашиг /алдагдал/	м.төг	1,651,657.3	96,776.2	1,903,252.6	251,595.3	115.2	1,806,476.4	1,966.7
6	Төсвийн төлбөрт нийт дүн	м.төг	58,019,459.5	59,848,857.9	63,672,108.7	5,652,649.2	109.7	3,823,250.8	106.4
	а/ Орлогын татварт	м.төг	554,984.5	10,752.9	866,493.5	311,509.0	156.1	855,740.6	8,058.2
	б/ НӨТ	м.төг	27,111,277.2	26,394,098.7	26,920,638.2	(190,639.0)	99.3	526,539.5	102.0
	в/ НДШ	м.төг	8,783,291.7	9,990,793.8	10,309,430.6	1,526,138.9	117.4	318,636.8	103.2
	г/ Хүн амын орлогын татвар	м.төг	5,187,056.3	6,097,829.3	6,755,051.1	1,567,994.9	130.2	657,221.8	110.8
	д/ Үл хөдлөх хөрөнгийн татвар	м.төг	1,080,118.8	989,429.4	1,120,032.5	39,913.7	103.7	130,603.1	113.2
	з/ Тээврийн хэрэгслийн татвар	м.төг	20,421.6	26,223.4	42,186.1	21,764.5	206.6	15,962.7	160.9
	ж/ Бусад татварт (улсын тэмдэгтийн хураамж)	м.төг	15,282,309.4	16,339,730.4	17,658,276.7	2,375,967.3	115.5	1,318,546.3	108.1
7	Төрийн өмчийн ногдол ашгийн өглөг	м.төг	-	-	-	-	-	-	-
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	1,118.0	1,122.0	1,118.0	-	100.0	(4.0)	99.6
9	Нийт цалингийн сан	м.төг	61,419,781.9	68,902,026.3	72,064,941.8	10,645,159.9	117.3	3,162,915.5	104.6
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	м.төг	4,261.7	4,718.0	4,987.9	726.2	117.0	269.9	105.7

Багануур ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	м.төг	1.0	1.0	1.0	0.0	100.1	0.0	101.0
12	Хөрөнгө оруулалт	м.төг	33,643,387.7	55,358,811.8	45,589,489.1	11,946,101.4	135.5	(9,769,322.7)	82.4
13	Нийт авлага	м.төг	6,644,508.1	6,644,508.1	8,675,588.3	2,031,080.2	130.6	2,031,080.2	130.6
	Үүнээс: Найдваргүй	м.төг	(660,736.2)	(660,736.2)	(1,006,248.6)	(345,512.5)	152.3	(345,512.5)	152.3
14	Нийт өглөг	м.төг	258,670,390.8	253,686,355.2	270,306,034.8	11,635,644.0	104.5	16,619,679.6	106.6
	Богино хугацаат өр төлбөр	м.төг	157,123,288.4	157,218,420.8	240,399,514.0	83,276,225.6	153.0	83,181,093.2	152.9
	Урт хугацаат өр төлбөр	м.төг	101,547,102.4	96,467,934.4	29,906,520.9	(71,640,581.5)	29.5	(66,561,413.5)	31.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компанийн үйл ажиллагаа

Багануур ХК нь Байгаль орчинд ээлтэй, сөрөг нөлөөгүй, дэвшилтэд техник, технологийг ашиглан үйлдвэрлэлийн үйл ажиллагааг явуулж, хэрэглэгчдийг стандарт чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүнээр хангаж, хувьцаа эзэмшигчдийн эдийн засгийн ашиг сонирхлыг эрхэмлэсэн үр ашигтай бизнес эрхлэхийг үндсэн зорилгоо болгон нүүрс олборлолт, баяжуулалт, боловсруулалт, борлуулалтын чиглэлийн үйл ажиллагаа явуулах чиг үүрэгтэй, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Эрхэм зорилгоо Тогтвортой хөгжлийг хангасан, мэдлэг инновацад суурилсан үндэсний тэргүүлэгч компани болоход оршино гэж тодорхойлсон байна.

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Багануур ХК-ийн нийт хувьцааны 75 хувийг төрийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа Эрдэнэс Монгол ХХК, 21.06 хувийг Монголиан коал корпорейшн ХХК, 3.94 хувийг аж ахуйн нэгж, хувь хүмүүс эзэмшиж байна. Мөн тус компани нь Багануур сувилал ХХК-ийн хувьцааг 100 хувь, Мон цахим ХХК-ийн хувьцааны 46 хувийг тус тус эзэмшиж байна.

Тус компани нь Компанийн тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чилэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль
- Авлигын эсрэг хууль
- Татварын ерөнхий хууль
- Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 3 дугаар тогтоолоор Компанийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1.6, 3.3.2, 3.5.1-т өөрчлөлт оруулсан байна.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 04 дүгээр тогтоолоор Компанийн зохион байгуулалт бүтэц, орон тооны дээд хязгаарыг шинэчлэн тогтоож, дотоод хяналтын албыг 5 орон тоотой ажиллахаар баталсан байна.

Тайлант онд дотоод хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөг 4 үндсэн зорилтын хүрээнд 23 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэх захирлаар батлуулан ажиллаж, 7,813.5 сая төгрөгийн 138 зөрчлийг илрүүлэн, 46 санал бүхий 11 тайлан тэмдэглэл, 81 үүрэг бүхий 18 зөвлөмж хүргүүлэн ажилласан байна. Зөвлөмжийн хэрэгжилт 78 хувийн гүйцэтгэлтэй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Багануур ХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус компани нь Эрдэнэс Монгол ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 76 дугаар тогтоолоор баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажилладаг бөгөөд уг баримт бичиг нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн боловч, санхүүжилт, дотоод хяналт, үйл ажиллагааны онцлогийг нарийвчлан тусгаагүй, ерөнхий байдлаар боловсруулсан шинээр батлагдан гарч буй стандарт, хууль тогтоомж, заавар, журамтай нийцүүлэн шинэчлэлт өөрчлөлт хийгдээгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Багануур ХК нь 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10,611.0 сая төгрөгөөр буюу 3.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	6,366,982.5	7,909,849.2	1,542,866.7
Авлага	6,644,508.1	8,675,588.3	2,031,080.2
Бараа материал	49,105,511.8	50,066,362.2	960,850.5
Урьдчилж төлсөн зардал тооцоо	2,312,000.0	2,570,356.8	258,356.8
Эргэлтийн бус хөрөнгө	201,094,759.7	206,912,583.8	5,817,824.1
Нийт хөрөнгө	265,523,762.1	276,134,740.4	10,610,978.3
Өр төлбөрийн нийт дүн	258,670,390.8	270,306,034.8	11,635,644.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	6,853,371.3	5,828,705.5	(1,024,665.7)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	265,523,762.1	276,134,740.4	10,610,978.3

Дээрх үзүүлэлтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, эргэлтийн бус хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчид нөлөө бүхий өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 7,909.8 сая төгрөг болж, 1,542.9 сая төгрөгөөр өссөн нь ДЦС-4 ТӨХК-аас 5,000.0 сая төгрөгийн нүүрсний төлбөрийг барагдуулсантай холбоотой;
- Нийт авлагын үлдэгдэл 8,675.6 сая төгрөг болж, 2,031.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь ДЦС-3 ХК, Дархан ДЦС, Төв Чандмань ДЭХГ-аас авах борлуулалтын авлага тайлант онд нийт 2,380.8 сая төгрөгөөр өссөнөөс шалтгаалсан;

Тайлант хугацаанд бусад авлага 361.4 сая төгрөгөөр буурсан.

- Бараа материал дансны үлдэгдэл 50,066.4 сая төгрөг болж, 960.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Технологийн автомашины засварын хэсгийн сэлбэгийн үлдэгдэл 1,217.5 сая төгрөгөөр өссөнөөс шалтгаалсан;
- Урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдэл 258.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь НӨАТ-ын хэрэгжээгүй авлага 258.4 сая төгрөгөөр, шатахууны картын тооцооны үлдэгдэл 8.2 сая төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой;

- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 206,912.6 сая төгрөг болж 5,817.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь уул уурхайн хөрөнгө 2,477.0 сая төгрөгөөр нэмэгдэж, барилга байгууламжийг 729.2 сая төгрөгөөр, уулын ажлын машин тоног төхөөрөмжийг 17,837.4 сая төгрөгөөр капиталжуулснаас шалтгаалсан;
- Өр төлбөр дансны үлдэгдэл 270,306.0 сая төгрөг болж, 11,635.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Тайлант хугацаанд Шунхлай трейдинг ХХК-д төлөх түлш, шатахууны өр 7,658.9 сая төгрөгөөр, Эрдэнэс Монгол ХХК-ийн зээл, хүүгийн төлбөр 5,341.1 сая төгрөгөөр, Майнс ап ХХК-д төлөх гидроэкскаваторын төлбөр 10,935.6 сая төгрөгөөр тус тус өссөнөөс шалтгаалжээ;
- Засгийн газрын хувь оролцоо буюу эздийн өмч оны эхнээс 1,024.7 сая төгрөгөөр буурч 5,828.7 сая төгрөг болсон нь ажилчдын тэтгэврийн сангийн 1,408.9 сая төгрөгийг хуримтлагдсан ашиг дансанд бүртгэж, 2024 оны цэвэр ашгаас 494.4 сая төгрөгийн ногдол ашиг олгосноос шалтгаалжээ;

Биет бус хөрөнгийн талаар авсан судалгаагаар тус дансанд 3.8 сая төгрөгийн хүний нөөцийн цогц программ, 43.9 сая төгрөгийн санхүүгийн цогц программ, 23 нэр төрлийн 789.5 сая төгрөгийн уурхайн тасаг хэлтсүүдэд ашиглах программ хангамж, нийт 25 нэр төрлийн 837.2 сая төгрөгийн программ хангамж бүртгэлтэй байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

3.5.1 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Багануур ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 33 дугаар тогтоолоор эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталж, 2025 оны 20 дугаар тогтоолоор тодотгосон байна. Тайлант оны нийт орлогыг 263,941.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 263,833.5 сая төгрөгөөр, 96.8 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд тайлант хугацаанд 48,523.1 сая төгрөгийг санхүүжүүлэхээр байна.

3.5.2 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Гүйцэтгэлээр 268,238.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 265,485.8 сая төгрөгийн зардал гарган, 2,752.4 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 268,238.2 сая төгрөг болж төлөвлөснөөс 4,297.3 сая төгрөг буюу 1.6 хувиар давсан нь 4,825.0 мян.тн нүүрс борлуулахаар төлөвлөснөөс, 19.8 мян.тн-оор илүү буюу 4,844.8 мян.тн нүүрс борлуулснаас шалтгаалсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 265,485.8 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1,652.4 сая төгрөг буюу 0.6 хувиар илүү гүйцэтгэлтэй байна. Энэ нь цалингийн сан 3,162.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Багануур ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 20 дугаар тогтоолоор эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд цалингийн санг тодотгоогүйгээс шалтгаалсан байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээнд 35 нэр төрлийн ажилд 48,523.1 сая төгрөгийг төлөвлөж, өөрийн эх үүсвэрээс 45,589.5 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 1,903.3 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1,806.5 сая төгрөгөөр илүү байгаа нь тайлант хугацаанд удирдлагын зардлыг 3,982.7 сая төгрөгөөр хэмнэснээс шалтгаалжээ.

Эрдэнэс Монгол ХХК-д тайлант онд ногдол ашгийн 371.6 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас судалгаа авч, үр дүнг тусгалаа. Үүнд:

- Багануур ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 7 дугаар тогтоолоор 1122 орон тоотой ажиллахаар дээд хязгаарыг тогтоосноос гүйцэтгэлээр удирдах 5, гүйцэтгэх 25, үйлчилгээний 1092 нийт 1122 үндсэн орон тоотойгоор ажилласан байна. Гүйцэтгэх захирлын 2025 оны 109 дүгээр тушаалаар 2025 онд түр ажлын байрны дээд хязгаарыг 90 орон тоотойгоор баталснаас гүйцэтгэлээр 45 орон тоотойгоор ажилласан;
Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 3 дугаар тогтоолоор Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 хувиар нэмж тогтоосонтой холбоотойгоор Багануур ХК-ийн гүйцэтгэх захирлын 2025 оны А/07 дугаар тушаалаар цалингийн сүлжээг 13-20 хувиар нэмэгдүүлэн шинэчлэн баталсан байна. Багануур ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 20 дугаар тогтоолоор эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд цалингийн зардлын хэмжээг нэмж тодотгоогүйгээс цалингийн зардал 3,162.9 сая төгрөгөөр, хоолны хөнгөлөлт 272.5 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн байна.
Гүйцэтгэх захирлын 2025 оны А/230 тоот тушаалаар хоолны хөнгөлөлтийг 11,935.00 төгрөг, унааны хөнгөлөлтийг 16,000.00 төгрөгөөр баталж, тайлант онд 2,285.0 сая төгрөгийг төлөвлөснөөс, 2,557.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 272.5 сая төгрөгөөр хэтэрсэн байна.
- Гадаад томилолтоор 5 арга хэмжээнд нийт 92.1 сая төгрөгийг төлөвлөж, гүйцэтгэлээр 66.9 сая төгрөгийг зарцуулсан;
- Тайлант онд 68 удаагийн нийт 196.1 сая төгрөгийн сургалт зохион байгуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр мэргэжил дээшлүүлэх сургалтад 76.7 сая төгрөг, тусгай эрх олгох сургалтад 39.4 сая төгрөг, бусад сургалтад 52.8 сая төгрөг, нийт 54 удаагийн сургалтад 168.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд нээлттэй тендер шалгаруулалтаар 164,594.2 сая төгрөгийн 68 бараа, ажил үйлчилгээг, харьцуулалтын аргаар 790.5 сая төгрөгийн 14 бараа, ажил үйлчилгээ, шууд худалдан авалтаар 3 төрлийн барааг 42.4 сая төгрөгөөр худалдан авахаар төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр www.tender.gov.mn цахим системд нээлттэй тендер шалгаруулалтаар шалгаруулалтаар 65 бараа, ажил, үйлчилгээг 160,108.1 сая төгрөгийн, харьцуулалтын аргаар 12 бараа, ажил, үйлчилгээг 759.8 сая төгрөгийн, шууд худалдан авалтаар 3 бараа, үйлчилгээг 42.4 сая төгрөгөөр худалдан авахаар худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 83 гүйцэтгэгчтэй нийт 130,208.8 төгрөгийн гэрээг байгуулсан байна.

Үүнээс 1 удаагийн 11,600.0 сая төгрөгийн барааг гэрээний хугацаанд нийлүүлээгүй, гэрээний үүргээ биелүүлэх тухай албан бичгийг 2 удаа хүргүүлсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Багануур ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Багануур ХК түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Аудитын хүрээнд Багануур сувилал ХХК-ийн санхүүгийн үйл ажиллагааг хамруулах горим сорил хэрэгжүүлсэн.

Мөн Багануур ХК-ийн үйл ажиллагааг сайжруулах үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоох саналыг хүргүүлэх, худалдан авсан нохойг бараа материалын дансанд бүртгэх, хойшлогдсон татварын хөрөнгийг жил бүр бүртгэж, тайлагнах худалдан авах ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн ахлах аудитор Г.Ариунбат, аудитор О.Эрдэнэчимэг, Ш.Солонго нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг чанарын хяналтын мэргэжилтэн С.Сождмаа, захирал С.Тунгалаг, Санхүүгийн аудитын газрын аудитор М.Ганбаатар, аудитын менежер Д.Энхдалай, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Багануур ХК нь 2025 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 9-ний өдрийн 01/188 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны зорилтот түвшний нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Багануур ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 33 дугаар тогтоолоор баталсан Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний нийт зардал 270,243.0 сая төгрөгөөс 1 хувиар буюу 2,702.4 сая төгрөгөөр тогтоож, Аудитын явцад Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 20 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний нийт зардал 263,833.5 сая төгрөгөөс 1 хувиар буюу 2,638.3 сая төгрөгөөр шинэчлэн тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан хуулиар хориглосон хязгаарласан арга хэмжээг тайлант онд санхүүжүүлээгүй байна.

Дотоод хяналтын албанаас Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэн 2026 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд хяналт хийж, тэвчиж болох 1,900.0 сая төгрөгийн зардлыг тодорхойлж, хяналт хариуцсан менежерт хүргүүлж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнд шаардлагатай мэдээллийг шилэн дансны нэгдсэн системд 154 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 3 мэдээллийг хоцроосон байна.

Багануур сувилал ХХК нь Шилэн дансны нэгдсэн системд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д "Тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор;" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь үнэн зөв байршуулж байх зөвлөмж өгсөн.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Илрүүлэлт 1: Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 20 дугаар тогтоолоор баталсан 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тогтоолд нийт авлагыг 6,644.5 сая, нийт өглөг 253,686.4 сая төгрөгөөр, нийт зардлыг 263,833.5 сая төгрөгөөр баталсан байна. Гүйцэтгэлээр нийт авлага зорилтот түвшнээс 2,031.1 сая төгрөгөөр, нийт өглөг 16,619.7 сая төгрөгөөр, нийт зардал 1,652.3 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3-т "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах", 71 дүгээр зүйлийн 8-д "Өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний үзүүлэлтийг хангаж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож албан шаардлага хүргүүлэв.

Багануур сувилал ХХК үндсэн үйл ажиллагааны чиглэлд тусгагдаагүй үйл ажиллагааг эрхэлж, тайлант онд 354 ш нийт 10.0 сая төгрөгийн согтууруулах ундааг худалдан, борлуусан байна.

Энэ нь Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.6-д "Энэ хуулийн 16.1, 16.2-т заасан тусгай зөвшөөрөл авах үйлчилгээний ангилал, тавигдах шаардлагыг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.", Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/419 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар "Согтууруулах ундаа худалдах үйлчлэх тусгай зөвшөөрөл авах үйлчилгээний ангилал" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үйл ажиллагааны чиглэлд тусгагдаагүй согтууруулах ундаа худалдан борлуулах үйл ажиллагаа эрхэлсэн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Багануур сувилал ХХК нь Байгууллагын онцлогт тохирсон ахмадын сангийн журамгүйгээр ахмадуудад хүндэтгэл үзүүлэх, буцалтгүй тусламж, тэтгэмж олгоход зарцуулсан байна.

Энэ нь Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолын 3 дугаар бүлгийн 3.3-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, төсвийн ерөнхийлөн захирагч энэ журмын 3.1.3, 3.1.9-д заасан

мөнгөн дэмжлэгийн хэмжээг тогтоож, дотоод журам, ажилтнуудын нийгмийн хамгааллын хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль тогтоомж, байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн Ахмадын сангийн журам боловсруулж, мөрдөж ажиллах зөвлөмж өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, цалин, шилэн дансны хуулийн хэрэгжилтэд горим, сорил хэрэгжүүлсэн. Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажууллаа.

Завсрын аудитаар нийт 4 зээлдэгчийн 8 төрлийн урт хугацаат зээлээс хуваарийн дагуу тайлант онд төлөх 71,949.9 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн төлөгдөөгүй зээлийн үлдэгдлийг богино хугацаат өр төлбөрийн ангилалд шилжүүлэн бүртгүүлж, шийдвэрлэгдээгүй бусад асуудлуудыг жилийн эцсийн аудитын тайланд тусгасан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 0.6 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 2,870.0 сая төгрөгийн 4 албан шаардлага, 3,219.0 сая төгрөгийн 3 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлж, 3.6 сая төгрөгийн 5 зөвлөмжөөс 2 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул албан шаардлага хүргүүлэв.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Д.д	Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
1	Төлбөрийн акт	1	618.7	1	618.7	100.0
2	Албан шаардлага	4	2,869,958.2	4	2,869,958.2	100.0
3	Зөвлөмж	5	3,609.1	3	3,609.1	60.0
4	Хариуцлага тооцоулах албан шаардлага	3	3,219,008.9	3	3,219,008.9	100.0
	Нийт дүн	13	6,093,194.9	11	6,093,194.9	84.6

1. Өмнөх оны аудитаар өгсөн 2 зөвлөмж хэрэгжээгүй тул албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

- Санхүүгийн программыг холбогдох хууль стандартад нийцүүлэн шинэчилж сайжруулах;
- Ажилчдын дундаж цалин хөлсийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу үнэн зөв тооцоолж олгох.

2. Мөн хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй ерөнхий нягтлан бодогчид хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, төрд учирсан хохирлыг тухайн буруутай шийдвэр гаргасан этгээдээр нөхөн төлүүлэх аудитын шийдвэр хэрэгжээгүй хохирол барагдаагүй тул дээд шатны төсөв захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхаарах асуудалд шилжүүлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудалд анхаарах шаардлагатай байна. Үүнд:

- Цаашид ашиглах боломжгүй болсон сэлбэг хэрэгсэл, аюулгүйн нөөц бүрдүүлэлт, шинэчлэл, нүүрс олборлолтын өртгийн тооцоолол;
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт батлагдан гарч буй стандарт, хууль тогтоомж, заавар, журамтай нийцүүлэн шинэчлэлт өөрчлөлт хийгдсэн эсэхэд дараагийн аудитаар горим сорил хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.
- Мөн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд олгосон үр дүнгийн шагналд зарцуулсан 33.0 сая төгрөгийн актын төлбөрөөс үлдэх 30.9 сая төгрөгийн үлдэгдлийг буруутай шийдвэр гаргасан этгээдээр нөхөн төлүүлээгүй байгаа асуудлыг ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийх аудитаар анхаарч үзэх шаардлагатай байна гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 79,301.4 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 64,426.5 сая төгрөгийн алдааг залруулж, 14,874.9 сая төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа:

- Санхүүгийн тайлангийн тодруулгыг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан маягтын дагуу иж бүрэн үнэн бэлтгэж, тайлагнаагүй байна. Өмчийн өөрчлөлтийн тайлангийн оны эхний үлдэгдлийг 62,242.1 сая төгрөгөөр дутуу тайлагнасан;
- Санхүүгийн тайланд тайлагнасан борлуулалтын орлогын дүн нь татварын цахим системийн төлбөрийн баримтад бүртгэгдсэн дүнгээс 722.2 сая төгрөгөөр дутуу тайлагнасан;
- Тайлант оны харилцах дансны үлдэгдэлд тооцсон хүүгийн орлогоос суутгасан 6.9 сая төгрөгийг хүүгийн орлогын албан татварыг үйл ажиллагааны бусад зардлаар бүртгэж, тайлагнасан;
- Нийт өр төлбөрийн үлдэгдлээс 11 байгууллагын нийт 961.1 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;
- Тайлант онд зарласан 2024 оны ногдол ашгийн өглөг 494.2 сая төгрөгийн ажил гүйлгээг Өмчийн өөрчлөлтийн тайлангийн зарласан ногдол ашиг хэсэгт бүртгэж, тайлагнаагүй байна.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д, 20.2.5-д холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, иж бүрэн байх, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийн хангаагүй байна.

Залруулаагүй алдаа:

Тайлант онд 14,874.9 сая төгрөгийн цалингийн урьдчилгааг олгохдоо цалингийн урьдчилгаа дансанд бичилт хийхгүйгээр цалингийн өглөг дансанд бүртгэж, тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах," Эрдэнэс Монгол ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 76 дугаар тогтоолоор баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй нийцээгүй, санхүүгийн тайлагналын толилуулга ба тодруулга үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цалингийн урьдчилгааг тооцооны дансанд бүртгэж, тайлагнах зөвлөмж хүргүүлэв.

Аудитаар нийт 14,877.0 сая төгрөгийн зөрчил² илэрсэнд, 27.7 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 2,645.8 сая төгрөгийн 5 албан шаардлага хүргүүлж, 12,203.6 сая төгрөгийн 5 зөвлөмж өгсөн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Аудитаар илэрсэн 14,877.0 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 12,238.7 сая төгрөгөөр их тул **"Хязгаарлалттай"** дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Цалингийн тооцооллыг давтан тооцоолоход 238 ажилтанд томилолтоор ажилласан хугацаанд 27.7 сая төгрөгийн хоолны хөнгөлөлтийг давхардуулан олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцээгүй санхүүгийн тайлагналын үнэлгээ ба хэмжилт, эрх ба үүрэг, үнэн зөв байх батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Томилолтоор ажилласан хугацаанд хоолны хөнгөлөлт олгосныг буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Нийт авлагын үлдэгдлээс 134 хувь хүн, хуулийн этгээдтэй холбоотой нийт 1,255.4 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалтыг мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд цалин хөлснөөс бусад 21.0 сая төгрөгийн гадаад томилолт, 1.3 сая төгрөгийн шатахууны зардал олгосон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 12-т "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсон төрийн албан хаагч эрх бүхий байгууллагаас тогтоосон цалин хөлснөөс бусад төрлийн шан харамж, урамшуулал авахыг хориглоно", Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журмын 7 дугаар зүйлийн 7.7-д "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн энэ журамд заасан цалин хөлснөөс бусад баталгаа, хангамж эдлэхийг хориглоно" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд цалин хөлснөөс бусад баталгаа, хангамж олгохыг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

3. Ээлжийн амралтын цалин хөлсийг давтан тооцоолоход 120 ажилтны дундаж цалин хөлсний тооцоололд нүүрсний хөнгөлөлтийг оруулж тооцсоны улмаас 2.3 сая төгрөгийг илүү тооцоолж олгосон ба өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 тушаалын хавсралтын 3.3-т "Ээлжийн амралтын цалин бодох дундаж цалин хөлсний бүрэлдэхүүнд үндсэн цалин, нэмэгдэл, САГ-2026/13/НА-СТА-ТӨҮГ

нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал багтана." гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын үнэлгээ ба хэмжилт, эрх ба үүрэг, үнэн зөв байх батламж мэдэгдлийг тус тус хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ээлжийн амралтын дундаж цалин хөлсөнд нүүрсний хөнгөлөлтийг нэмж тооцохыг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5. Өмнөх аудитаар өгсөн Санхүүгийн программыг холбогдох хууль стандартад нийцүүлэн шинэчилж сайжруулах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар илэрсэн алдаа зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг биелүүлэх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Аваар ослын үед эрэн хайхад ашиглах зорилгоор 5.0 сая төгрөгөөр худалдан авсан 2 нохойг нягтлан бодох бүртгэлд бүртгэж, тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, иж бүрэн байх, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийн хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авсан нохойг бараа материалын дансанд бүртгэж тайлагнах

2. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Санхүүгийн тайланд тайлагнасан хойшлогдсон татварын хөрөнгө дансны 764.4 сая төгрөгийн үлдэгдэлд 2020 оноос хойш тооцоолол хийгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 6-д" Хойшлогдсон татварын хөрөнгөнд хасагдах түр зөрүү болон ашиглагдаагүй татварын алдагдлыг дараагийн үе рүү шилжүүлэхтэй холбоотойгоор ирээдүйн тайлант үед нөхөгдөх орлогын албан татварын дүн хамаарна. Хойшлогдсон татварын хөрөнгийг НББОУС 12 Орлогын албан татварын дагуу тооцож бүртгэнэ. Аж ахуйн нэгж нь хасагдах түр зөрүүг ашиглаж болохуйц хэмжээний татвар ногдох ашиг олох магадлалтай байгаа үед л хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. Аж ахуйн нэгж нь тайлангийн өдөр бүрээр хүлээн зөвшөөрөөгүй хойшлогдсон татварын хөрөнгийг дахин авч үзнэ. Аж ахуйн нэгж нь хүлээн зөвшөөрөөгүй хойшлогдсон татварын хөрөнгийг нөхөх боломж олгохуйц татвар ногдох ашиг ирээдүйн тайлант үед олох нь тодорхой байгаа үед өмнөх хүлээн зөвшөөрөөгүй хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. Хэрэв хойшлогдсон татварын хөрөнгийн бүх эсвэл зарим өгөөжийг ашиглах хангалттай хэмжээний татвар ногдуулах орлого олох магадлалгүй бол тэр хэмжээгээр хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг бууруулна гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын үнэлгээ ба хэмжилт, оршин байх, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хойшлогдсон татварын хөрөнгийг үнэн зөв тооцоолж, санхүүгийн тайланд жил бүр бүртгэж тайлагнах

3. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 1552 нэр төрлийн 83,685.6 сая төгрөгийн хөрөнгийг бодит үнэ цэнээр бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмыг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын үнэлгээ ба хэмжилт батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн ашиглах боломжтой хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэж төлөөлөн удирдах зөвлөлд хүргүүлж шийдвэрлүүлэн бүртгэх.

4. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Хөрс тээврийн автосамосвал нийлүүлэх 11,600.0 сая төгрөгийн 25/12-54 дүгээр гэрээний тусгай нөхцөлийн ГЕН 2.6-д 90 хоногийн дотор барааг нийлүүлэхээр заасан ч уг барааг нийлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39-т "39.3.6-д "Бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх хуваарь", 40 дүгээр зүйлийн 40.4-т "Энэ хуулийн 10.11-д заасны дагуу байгуулсан гэрээний хугацааг сунгахыг хориглоно.", "Хөрс тээврийн Автосамосвал нийлүүлэх №БНХК/20250102018 тоот №25/12-54 дугаар бүхий гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйлийн 5.1.4 ,5.5.5-д заасны дагуу гэрээг цуцлах мэдэгдэл хүргүүлэх" гэсэнтэй нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авах ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, гэрээний нөхцөл, заалтыг мөрдүүлэх, гэрээний үүргийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах

5.4 Багануур сувилал ХХК-ийн санхүүгийн тайланд хийсэн аудит

Охин компанийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1,964 сая төгрөгийн 2 зөрчил илэрснээс 1,365.7 сая төгрөгийн 1 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 598.6 сая төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгсөн. Үүнд:

5.4.1 Албан шаардлага

Илрүүлэлт 1: Худалдан авах ажиллагааг зохин байгуулахдаа нээлттэй тендер шалгаруулалтын арга ашиглаагүй 4 байгууллагаас 844.6 сая төгрөгийн, харьцуулалтын арга ашиглаагүй 12 байгууллагаас 521.1 сая төгрөгийн, нийт 16 байгууллагаас 1,365.7 сая төгрөгийн барааг шууд худалдан авсан байна.

Энэ нь Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолын хавсралт "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар"-т Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 20.0 сая төгрөг байна", "48 дугаар зүйлийн 48.7-д "Захиалагч энэ хуулийн 35, 36 дугаар зүйлд заасны дагуу гэрээ байгуулсан тохиолдолд гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт гэрээ байгуулснаас хойш ажлын 10 өдрийн дотор Авлигатай тэмцэх газарт хүргүүлнэ" гэж заасныг мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалт, харьцуулалтын аргаар зохион байгуулаагүй шууд худалдан авсан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5.4.2 Зөвлөмж

3. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 245 нэр төрлийн 598.6 сая төгрөгийн хөрөнгийг бодит үнэ цэнээр бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмыг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын үнэлгээ ба хэмжилт батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн ашиглах боломжтой хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэж төлөөлөн удирдах зөвлөлд хүргүүлж шийдвэрлүүлэн бүртгэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Санхүүгийн тайлангийн тодруулгыг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан маягтын дагуу иж бүрэн үнэн бэлтгэж, тайлагнаагүй байна. Өмчийн өөрчлөлтийн тайлангийн оны эхний үлдэгдлийг 62,242.1 сая төгрөгөөр дутуу тайлагнасан.	1	62,242,062.8	-	-	1	62,242,062.8	1	62,242,062.8	-	-	-	-
2	Санхүүгийн тайланд тайлагнасан борлуулалтын орлогын дүн нь татварын цахим системийн төлбөрийн баримтад бүртгэгдсэн дүнгээс 722.2 сая төгрөгөөр дутуу тайлагнасан байна.	1	722,219.7	-	-	1	722,219.7	1	722,219.7	-	-	-	-
3	Тайлант оны харилцах дансны үлдэгдэлд тооцсон хүүгийн орлогоос суутгасан 6.9 сая төгрөгийг хүүгийн орлогын албан татварыг үйл ажиллагааны бусад зардлаар бүртгэж, тайлагнасан байна.	1	6,912.4	-	-	1	6,912.4	1	6,912.4	-	-	-	-
4	Нийт өр төлбөрийн үлдэгдлээс 11 байгууллагын нийт 961.1 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	961,111.0	-	-	1	961,111.0	1	961,111.0	-	-	-	-
5	Тайлант онд 14,874.9 сая төгрөгийн цалингийн урьдчилгааг олгохдоо цалингийн урьдчилгаа дансанд бичилт хийхгүйгээр цалингийн өглөг дансны дт-д бүртгэж, тайлагнасан байна.	1	14,874,848.4	-	-	1	14,874,848.4	-	-	1	14,874,848.4	1	14,874,848.4
6	Тайлант онд зарласан 2024 оны ногдол ашгийн өглөг 494.2 сая төгрөгийн ажил гүйлгээг Өмчийн өөрчлөлтийн тайлангийн зарласан ногдол ашиг хэсэгт бүртгэж, тайлагнаагүй байна.	1	494,199.9	-	-	1	494,199.9	1	494,199.9	-	-	-	-
Дүн		6	79,301,354.2	-	-	6	79,301,354.2	5	64,426,505.8	1	14,874,848.4	1	14,874,848.4

6.2. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Нийт авлагын үлдэгдлээс 134 хувь хүн, хуулийн этгээдтэй холбоотой нийт 1,255.4 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	1,255,374.0	-	-	1	1,255,374.0	-	-	-	-	-	-
2	Аваар ослын үед эрэн хайхад ашиглах зорилгоор 5.0 сая төгрөгөөр худалдан авсан, 2 нохойг нягтлан бодох бүртгэлд бүртгэж, тайлагнаагүй байна.	1	5,000.0	-	-	-	-	1	5,000.0	-	-	-	-
3	Санхүүгийн тайланд тайлагнасан хойшлогдсон татварын хөрөнгө дансны 764.4 сая төгрөгийн үлдэгдэлд 2020 оноос хойш тооцоолол хийгээгүй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
4	ТУЗ-ийн гишүүдэд цалин хөлснөөс бусад 21.0 сая төгрөгийн гадаад томилолт, 1.3 сая төгрөгийн шатахууны зардал олгосон байна.	1	22,404.1	-	-	1	22,404.1	-	-	-	-	-	-
5	Цалингийн тооцооллыг давтан тооцоолоход 238 ажилтанд томилолтоор ажилласан хугацаанд 27.7 сая төгрөгийн хоолны хөнгөлөлтийг давхардуулан олгосон байна.	1	27,690.1	1	27,690.1	-	-	-	-	-	-	-	-
6	Хөрс тээврийн автосамосвал нийлүүлэх 11,600.0 сая төгрөгийн 25/12-54 дүгээр гэрээний тусгай нөхцөлийн ГЕН 2.6-д 90 хоногийн дотор барааг нийлүүлэхээр заасан ч уг барааг нийлүүлээгүй байна.	1	11,600,000.0	-	-	-	-	1	11,600,000.0	-	-	-	-

Багануур ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

7	Ээлжийн амралтын цалин хөлсийг давтан тооцоолоход 120 ажилтны дундаж цалин хөлсний тооцоололд нүүрсний хөнгөлөлтийг оруулж тооцсоны улмаас 2.3 сая төгрөгийг илүү тооцоолж олгосон ба өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	1	2,251.9	-	-	1	2,251.9	-	-	-	-	-	-
8	Өмнөх аудитаар өгсөн Санхүүгийн программыг холбогдох хууль стандартад нийцүүлэн шинэчилж сайжруулах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-
9	Үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 1552 нэр төрлийн 83,685.6 сая төгрөгийн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоож, ашиглалтын хугацааг сунгаагүй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Багануур ХК-ийн дүн			9 12,912,720.1	1	27,690.1	4	1,280,030.0	4	11,600,000.0				
10	Ашиглах боломжтой элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 245 нэр төрлийн 598.6 сая төгрөгийн хөрөнгийг өнөөгийн үнэ цэнээр бүртгээгүй байна.	1	598,569.3	-	-	-	-	1	598,569.3	-	-	-	-
11	Шалгагдагч байгууллага нь нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 4 байгууллагын 844.6 сая төгрөг, харьцуулалтын аргаар худалдан авч болох 12 байгууллагын 521.1 сая төгрөг, нийт 16 байгууллагаас 1,365.7 сая төгрөгийн барааг тендер шалгаруулахгүйгээр шууд худалдан авсан байна.	1	1,365,716.8	-	-	1	1,365,716.8	-	-	-	-	-	-
Багануур сувилал ХХК-ийн дүн			2 1,964,286.1			1	1,365,716.8	1	598,569.3				
Нийт дүн			11 14,877,006.2	1	27,690.1	5	2,645,746.8	5	12,203,569.3				

6.3. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
1	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 20 дугаар тогтоолоор баталсан 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тогтоолд нийт авлагыг 6,644.5 сая, нийт өглөг 253,686.4 сая төгрөгөөр, нийт зардлыг 263,833.5 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр нийт авлага 2,031.1 сая төгрөгөөр, нийт өглөг 16,619.7 сая төгрөгөөр, 1,652.3 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн байна.	1	20,303,131.5	-	-	1	20,303,131.5	-	-
Багануур ХК-ийн дүн		2	20,303,131.5	-	-	1	20,303,131.5	-	-
2	Шилэн дансны нэгдсэн системд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан байршуулаагүй байна.	1	-	-	-	-	-	1	-
3	Шалгагдагч байгууллага нь үндсэн үйл ажиллагааны чиглэлд тусгагдаагүй үйл ажиллагааг эрхэлж, тайлант онд 354 ш нийт 10.0 сая төгрөгийн согтууруулах ундааг худалдан, борлуусан байна.	1	10,001.2	-	-	1	10,001.2	-	-
4	Байгууллагын онцлогт тохирсон ахмадын сангийн журамгүйгээр ахмадуудад хүндэтгэл үзүүлэх, буцалтгүй тусламж, тэтгэмж олгоход зарцуулсан байна.	1	-	-	-	-	-	1	-
Багануур сувилал ХХК-ийн дүн		3	10,001.2	-	-	1	10,001.2	2	-
Нийт дүн		4	20,313,132.7	-	-	2	20,313,132.7	2	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 185/A0150053

Улаанбаатар хот

САГ - 2026/13/НА - СТА - ТӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Багануур ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цалингийн тооцооллыг давтан тооцоолоход 238 ажилтанд томилолтоор ажилласан хугацаанд 27,690,110.00 /Хорин долоон сая зургаан зуун ерэн мянга нэг зуун арван/ төгрөгийн хоолны хөнгөлөлтийг давхардуулан олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасныг мөрдөөгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3 "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон;"-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Цалин, хоолны хөнгөлөлтийг давхардуулан олгосон 27,690,110.00 /Хорин долоон сая зургаан зуун ерэн мянга нэг зуун арван/ төгрөгийг Үндэсний аудитын газрын төрийн санд дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Багануур ХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Т.Отгонболд/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Наранбаатар/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ

С.ТУНГАЛАГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 905/A0150053

Улаанбаатар хот

САГ-2026/13/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Багануур ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд цалин хөлснөөс бусад 21,032,273.00 /Хорин нэгэн сая гучин хоёр мянга хоёр зуун далан гурав/ төгрөгийн гадаад томилолт, 1,371,811.00 /Нэг сая гурван зуун далан нэгэн мянга найман зуун арван нэгэн/ төгрөгийн шатахууны зардал олгосон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 12-т "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсон төрийн албан хаагч эрх бүхий байгууллагаас тогтоосон цалин хөлснөөс бусад төрлийн шан харамж, урамшуулал авахыг хориглоно", Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журмын 7 дугаар зүйлийн 7.7-д "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн энэ журамд заасан цалин хөлснөөс бусад баталгаа, хангамж эдлэхийг хориглоно" гэж заасныг мөрдөөгүй байна

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд цалин хөлснөөс бусад хангамж олгосон зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Багануур ХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Т.Отгонболд/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Наранбаатар/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ

С.ТУНГАЛАГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 904/А0150053

Улаанбаатар хот

САГ - 2026/13/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Багануур ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ээлжийн амралтын цалин хөлсийг давтан тооцоолоход 120 ажилтны дундаж цалин хөлсний тооцоололд нүүрсний хөнгөлөлтийг оруулж тооцон 2,251,918.00 /Хоёр сая хоёр зуун тавин нэгэн мянга есөн зуун арван найман/ төгрөгийг илүү олгосон, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06 -ны өдрийн А/191 тушаалын хавсралтын 3.3-т "Ээлжийн амралтын цалин бодох дундаж цалин хөлсний бүрэлдэхүүнд үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал багтана." гэж заасныг мөрдөөгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, дундаж цалин хөлсийг алдаатай тооцсон зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх,
2. Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Багануур ХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Т.Отгонболд/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Наранбаатар/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ

С.ТУНГАЛАГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 903/АД150053

Улаанбаатар хот

САГ-2026/13/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Багануур ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар өгсөн Санхүүгийн программыг холбогдох хууль стандартад нийцүүлэн шинэчилж сайжруулах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, санхүүгийн программ нь харилцагч үүсгэсэн тухайн өдрөөс хойших нийт ажил, гүйлгээний үлдэгдлийг харуулж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2022 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Аудит хийх журам"-ын 19.1-д "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Санхүүгийн программыг холбогдох хууль стандартад нийцүүлэн сайжруулах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, шинэчлэлт, хөгжүүлэлт хийгээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Багануур ХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Т.Отгонболд/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Наранбаатар/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ

С.ТУНГАЛАГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 902/АД150053

Улаанбаатар хот

САГ-2026/13/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Багануур ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 20 дугаар тогтоолоор баталсан 2025 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тогтоолд нийт авлагыг 6,644,508,100.00 /Зургаан тэрбум зургаан зуун дөчин дөрвөн сая таван зуун найман мянга нэг зуун/ төгрөг, нийт өглөгийг 253,686,355,200.00 /Хоёр зуун тавин гурван тэрбум зургаан зуун наян зургаан сая гурван зуун тавин таван мянга хоёр зуун/ сая төгрөгөөр, нийт зардлыг 263,833,457,800.00 /Хоёр зуун жаран гурван тэрбум найман зуун гучин гурван сая дөрвөн зуун тавин долоон мянга найман зуун/төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр нийт авлага 2,031,080,200.00 /Хоёр тэрбум гучин нэгэн сая наян мянга хоёр зуун/ төгрөгөөр, нийт өглөг 16,619,679,600.00 /Арван зургаан тэрбум зургаан зуун арван есөн сая зургаан зуун далан есөн мянга зургаан зуун/ төгрөгөөр, нийт зардлыг 1,652,371,700.00 /Нэг тэрбум зургаан зуун тавин хоёр сая гурван зуун далан нэгэн мянга долоон зуун/ төгрөгөөр тус тус хэтэрсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3-д "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах", 71 дүгээр зүйлийн 8-д "Өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх", гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Санхүүгийн үзүүлэлт, зорилтот түвшнийг хангаж ажиллаагүй, авлага, өр төлбөр, зардлыг хэтрүүлсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Багануур ХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Т.Отгонболд/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Наранбаатар/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ

С.ТУНГАЛАГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 901/АД150053

Улаанбаатар хот

САГ-2026/13/КА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Багануур ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийт авлагын үлдэгдлээс 134 хувь хүн, хуулийн этгээдтэй холбоотой нийт 1,255,373,958.00/ Нэг тэрбум хоёр зуун тавин таван сая гурван зуун далан гурван мянга есөн зуун тавин найман/ төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"; гэж заасныг мөрдөөгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-т "Авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тайлант хугацаанд авлагын тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Багануур ХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Т.Отгонболд/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Наранбаатар/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ

С.ТУНГАЛАГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 907/A0150053

Улаанбаатар хот

САГ-2026/11/НА-СТА-ТӨА

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Багануур сувилал ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шалгагдагч байгууллага нь үндсэн үйл ажиллагааны чиглэлд тусгагдаагүй үйл ажиллагааг эрхэлж, тайлант онд 354 ш нийт 10,001,233.09 /Арван сая нэг мянга хоёр зуун гучин гурван төгрөг өсөн мөнгө/ төгрөгийн согтууруулах ундааг худалдан, борлуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.7-д "байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах.", Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.6-д "Энэ хуулийн 16.1, 16.2-т заасан тусгай зөвшөөрөл авах үйлчилгээний ангилал, тавигдах шаардлагыг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.", Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн А/419 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар "Согтууруулах ундаа худалдах үйлчлэх тусгай зөвшөөрөл авах үйлчилгээний ангилал" гэж заасныг мөрдөөгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн

ШААРДАХ нь:

1. Үйл ажиллагааны чиглэлд тусгагдаагүй согтууруулах ундаа худалдан борлуулах үйл ажиллагаа эрхэлдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Багануур сувилал ХХК-ийн гүйцэтгэх захирал /О.Батмөнх/, ерөнхий нягтлан бодогч /Т.Дулам/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ

С.ТУНГАЛАГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 906/А0150053

Улаанбаатар хот

САГ-2026/11/НА-СТА-ТӨА

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Багануур сувилал ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шалгагдагч байгууллага нь нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 4 байгууллагаас 844,582,703.97 /Найман зуун дөчин дөрвөн сая таван зуун наян хоёр мянга долоон зуун гурван төгрөг ерэн долоон мөнгө/ төгрөг, харьцуулалтын аргаар худалдан авч болох 12 байгууллагаас 521,134,079.50 /Таван зуун хорин нэгэн сая нэг зуун гучин дөрвөн мянга далан есөн төгрөг тавин мөнгө/ төгрөг, нийт 16 байгууллагаас 1,365,716,783.47 /Нэг тэрбум гурван зуун жаран таван сая долоон зуун арван зургаан мянга долоон зуун наян гурван төгрөг дөчин долоон мөнгө/ төгрөгийн барааг тендер шалгаруулахгүйгээр шууд худалдан авсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 10.12-т "Энэ хуулийн 10.2, 34.1-д заасан төсөвт өртгийн дээд хязгаарыг Засгийн газар тогтооно." Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолын хавсралт "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар"-т Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 20.0 сая төгрөг байна", "48 дугаар зүйлийн 48.7-д " Захиалагч энэ хуулийн 35, 36 дугаар зүйлд заасны дагуу гэрээ байгуулсан тохиолдолд гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт гэрээ байгуулснаас хойш ажлын 10 өдрийн дотор Авлигатай тэмцэх газарт хүргүүлнэ" гэж заасныг мөрдөөгүй байна" гэж заасныг мөрдөөгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалт, харьцуулалтын аргаар зохион байгуулдаггүй шууд худалдан авсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Багануур сувилал ХХК-ийн гүйцэтгэх захирал /О.Батмөнх/, ерөнхий нягтлан бодогч /Г.Дулам/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ

С.ТУНГАЛАГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230



9006109
ATA16087
9025081411

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-61.Docx